



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20²⁰ оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/466

Алтай хот

Г Хичээлийн шинэ жилийн бэлтгэл Г
ажил хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2020 оны "Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан санхүү төсөв, хүний нөөц, барилга байгууламж, засвар үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийн бэлэн байдлын бэлтгэл ажил хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр

Гишүүд:


	Б.Алтайбаатар	-аймгийн Засаг даргын Нийгмийн бодлого эрхэлсэн орлогч
	П.Баасан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Т.Энхцэцэг	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Р.Батмөнх	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ц.Туяа	-Боловсрол, соёл урлагийн газрын дарга
	О.Мөнхбаатар	-Эрүүл мэндийн газрын дарга
	Т.Дэлгэрцэцэг	-Мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч
	С.Энхбаяр	-Мэргэжлийн хяналтын газрын Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 59 дүгээр ангийн захирагч
Нарийн бичгийн дарга:	С.Цагаанбаатар	-Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, соёлын бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Бэлтгэл ажлыг сайтар хангуулахад зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ажиллаж, боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг 9 дүгээр сарын 01-ний өдөр эхлэхэд бэлэн болгож, тайлан мэдээг Засаг даргын зөвлөлийн

2.

хуралд танилцуулж, Улсын онцгой комисст хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ